УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2020 оны 08 сарын 19 өдөр Дугаар А/246 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Хөрөнгө гаргах тухай" А/1034 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2020-2021 оны өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй болон хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангах ажлын хүрээнд гүйцэтгэх сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ, дээврийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасан ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Батлагдсан ажлын гүйцэтгэгчийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо /Т.Хэрлэн/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

c:\users\gantuya\desktop\үж 12\doc 2020\тушаал 3doc.docx

1110300819

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 08 сарын 19 өдрийн
А/246 тушаалын 1 дүгээр хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	М.Балдандорж	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Энхбат	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 08 сарын 19 өдрийн
А/246 тушаалын 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН 2020-2021 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН
ҮЕД ХҮНДЭРЧ БОЛЗОШГҮЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ,
ЭМНЭЛГИЙН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ,
ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГСААЛТ,

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг /сая төг/	2020 онд санхүүжих дүн
1	2	3	4	5
1	93 дугаар цэцэрлэгийн цэвэр, бохир усны сантехникийн засвар /БГД, 8 дугаар хороо/	2020 он	60.00	60.00
2	96 дугаар сургуулийн урлаг заалны дээврийн засвар /БГД, 18 дугаар хороо/, 54 дүгээр сургуулийн урлаг заалны дээврийн засвар /БГД, 18 дугаар хороо/	2020 он	68.00	68.00
3	88 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажил /БГД, 18 дугаар хороо/	2020 он	76.00	76.00
4	141 дүгээр цэцэрлэгийн дээврийн засвар /БГД, 10 дугаар хороо/	2020 он	137.00	137.00
5	31 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугам засвар/СБД, 2 дугаар хороо/, Эрүүл мэндийн төвийн Салбар амбултор 1-ийн гадна дулааны шугам засвар /СБД, 3 дугаар хороо/, 37 дугаар сургуулийн гадна дулааны шугамын засвар /ЧД, 17 дугаар хороо/	2020 он	85.00	85.00
6	2 дугаар сургуулийн дулааны шугамын засвар /СБД, 7 дугаар хороо/	2020 он	81.00	81.00
7	99 дүгээр цэцэрлэгийн цэвэр, бохир усны шугам, дээврийн засварын ажил /СХД, 13 дугаар хороо/	2020 он	79.00	79.00
8	67 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажил /ХУД, 1 дүгээр хороо/, 132 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажил /БНД, 4 дүгээр хороо/	2020 он	69.00	69.00
9	82 дугаар сургуулийн урлаг заалны дээврийн засвар /СХД, 16 дугаар хороо/, 83 дугаар сургуулийн урлаг заалны дээврийн засвар /СХД, 17 дугаар хороо/	2020 он	68.00	68.00
ДҮН			**723.00**	**723.00**